



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/162

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 634 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрчим хүчний үнэ тариф нэмэгдсэнтэй холбоотойгоор иргэдээс ирсэн санал гомдлыг үндэслэн хяналт шалгалт хийж, шаардлагатай мэдээлэл гаргаж, эрчим хүчний яаманд уламжлах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Э. Уртнасан (Засаг даргын орлогч)

Гишүүд: Д.Эрдэнэбат (Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Р.Янжмаа (Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга)

З.Батзаяа (Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

С.Гантөмөр ("Ховд цахилгаан түгээх сүлжээ" ХХК-ийн захирал)

Б.Уртнасан ("Ховд цахилгаан түгээх сүлжээ" ХХК-ийн борлуулалтын албаны дарга)

Б.Батзул (Иргэний төлөөлөл)

М.Номинжаргал (Иргэний төлөөлөл)

Б.Баттөмөр (Иргэний төлөөлөл)

Б.Чулуунсүрэн (Иргэний төлөөлөл)

Б.Цэрэнчимэд (Иргэний төлөөлөл)


Д.Мөнхболд (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн

дарга: Н.Цацралцэцэг (Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

2. Эрчим хүчний үнэ тариф нэмэгдсэнтэй холбоотойгоор иргэдээс ирсэн санал гомдлыг үндэслэн хяналт шалгалт хийж, шаардлагатай мэдээлэл гаргаж эрчим хүчний яаманд уламжлахыг ажлын хэсгийн ахлагч (Э.Уртнасан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА